# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 15 өдөр Дугаар 19 Улаанбаатар хот

Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, 2024 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Дүүргийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

3.Дүүргийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1150100073

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын
15-ны өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт

# ДҮҮРГИЙН 2024 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

## НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

| Д/д | Хэрэгжүүлэх ажил | Хариуцах байгууллага | Хугацаа | Төлөвлөгөөнд тусгах үндэслэл |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Нэг. Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил | | | | |
| 1. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох хэсэг дүүргийн нутаг дэвсгэрт өөрчлөлт оруулан батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан зарим хил нь олон жил суурьшин амьдарч буй иргэдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газартай давхацсан, зарим хэсэгт тогтоолд авах шаардлагагүй газруудыг хамааруулсан зэргээс шалтгаалан тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учирч, Монгол Улсын Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дэх заалтууд бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа тул тогтоолыг өөрчлөх шаардлагатай болсон |
| 2. | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг Улаанбаатар хотын эдэлбэр газар, түүнтэй холбоотой дүрэм, журмын төсөл шинэчлэн боловсруулах, батлуулах | ДГЗБА | I-IV улиралд | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль |
| Хоёр. Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 3. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө", Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт |
| 4. | Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дах заалт, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах | | | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт |
| 5. | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг цахимжуулах, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Газрын бирж"-ийн цахим систем /www.mle.mn/ -ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 23.2.7 "Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах" дах заалт; Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 152 дугаар тогтоол |
| 6. | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, системийн хөгжүүлэлтийг хийх, хэрэгжилтийг зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт |
| 7. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох | ДГЗБА | I-IV улиралд | Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай 58 дугаар зарлигийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2021 оны 03 дугаар зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамж |
| **Гурав. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил** | | | | |
| Хот байгуулалтын чиглэлээр: | | | | |
| 8. | Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нөхөн олговор олгохоор тусгагдсан бүтээн байгуулалтын ажлуудад газар чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх | ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны ,,,,, тогтоол |
| 9. | Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | ДЗДТГ , ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль |
| 10. | Орон сууцны хороолол дундах автомашины гараашнуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэн нийтийн эдэлбэр газраар бүртгэлжүүлэх, сургууль, цэцэрлэгийн байгууллагад боломжит байршлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4 дэх заалт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, ЗТБХБ Сайдын 2010 оны 418 дугаар тушаал |
| 12. | Авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол |
| 13. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 26 амны ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулахтай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I- IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.1.2 дах заалт |
| 14. | Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах. | ДЗДТГ, ДГЗБА | I- IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.5, 9.1.2 дах заалт |
| 15. | Дүүргийн нутаг дэвсгэрт шинээр байгуулагдсан хороодын нийгмийн хангамжийн барилга, байгууламжийн газрын асуудлыг шийдвэрлэх | ДЗДТГ, ДГЗБА | I- IV улиралд | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/36 дугаар тогтоол |
| 16. | Дүүргийн нутаг дэвсгэрт явган зам болон дугуйн зам, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, ногоон байгууламжийн газрын байршлын судалгааг гаргаж, холбогдох ажлыг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |
| 17. | Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийг судлан, дүн шинжилгээ хийж дүүргийн Засаг даргын захирамжаар цуцлах, тухайн байршилд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тохижилт, ногоон байгууламж, биеийн тамирын талбайг байгуулах ажлыг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 61.1 "Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно" дэх заалт |
| ***Газар зохион байгуулалтын чиглэлээр:*** | | | | |
| 18. | Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах. | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Хот тосгон бусад суурин газрын мониторингийн 300 цэгт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хөрсний бохирдлын судалгааны ажлыг зохион байгуулах" удирдамж |
| 19. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Дамбадаржаа, Дэнжийн мянга, Шархад, Толгойт дэд төвүүдийн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.2.2 дах заалт |
| 20. | Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах, зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах. | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дах заалт |
| 21. | Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгагдсаны дагуу<br>1.Улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарсан байршилтай давхацсан,<br>2.Улс, нийслэлийн төсөв, гадаад зээл, тусламжаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх байршилтай давхацсан,<br>3.Хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газартай давхацсан,<br>4.Геодезийн солбицол, өндөр тусгагийн тогтолцоо өөрчлөгдсөн,<br>5.Газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэх,<br>6.нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн,<br>7.Хүн ам, барилгажилтын нягтрал ихтэй бүсэд байрлах газрыг нийтийн эдэлбэр газарт авах, нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн шийдвэр зэргийг үндэслэн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар ашиглалтын бүсчлэлд нийцүүлэн эзэмшил газрын хэмжээ, байршлыг өөрчлөх үйл ажиллагааг зохион байгуулах /200га/ | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 22. | Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газар эзэмшигч ашиглагчийн гэрээг, дүгнэх хэрэгжилтэд хяналт тавих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | ДЗДТГ , ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хууль |
| 23. | Газрын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төлбөрийн бүртгэлийг сайжруулах талаар санал өгч арга хэмжээг зохион байгуулах | ДЗДТГ , ДГЗБА | I-IV улиралд | Газрын төлбөрийн тухай хууль |
| 24. | Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газар эзэмшиж ашиглаж байгаа иргэн хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацаа сунгах, зориулалт, талбайн хэмжээ, байршил кадастрын зургийн хэлбэр, хаяг өөрчлөх, хүсэлтийг шийдвэрлэх Дүүргийн Засаг даргын дэргэдэх "Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэн гарсан шийдвэрийн дагуу өөрчлөлт орсон нэгж талбарын мэдээллийг тухай бүрд баяжуулж газрын цахим мэдээллийн санг хөтлөх | ДГЗБА | I-IV улиралд | Газрын хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах |
| 25. | Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болгох үндэслэл бүрдсэн газар эзэмшигч ашиглагчийн судалгааг гаргаж, "газар эзэмших эрх, эрхийн гэрчилгээг" хүчингүй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл |
| 26. | Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь дуусгавар болох үндэслэл бүрдсэн газар эзэмшигч ашиглагчийн судалгааг гаргаж, "газар эзэмших эрхийг" дуусгавар болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйл |
| 27. | Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дах заалт |
| 28. | Усан сан бүхий газар, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсэд өртсөн нэгж талбаруудын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг дуусгавар болгох, хүчингүй болгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах. | ДЗДТГ<br>ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйл, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл, 60 дугаар зүйл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 29. | Газар өмчилсөн иргэдийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх | ДГЗБА | I-IV улиралд | "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах |
| 30. | Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу |
| 31. | Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх | ДГЗБА | I-IV улиралд | Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол |
| 32. | Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо Хайлааст, Хандгайт, Яргайт, Рашаан, Ногооны талбайн байршлуудад холбогдох хууль, журмын дагуу иргэний хүсэлтийг үндэслэн эзэмшиж буй газрыг өмчлүүлэх | ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлийн 9.6 дэх заалт;<br>"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах |
| Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 33. | Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийг судлан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний талбайг хэсэгчлэн буюу бүхлээр нь хүчингүй болгох зэрэг холбогдох арга хэмжээг авах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1-д "Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно" дэх заалт |
| 34. | Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Газар эзэмших ашиглах эрхийг хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, дүйцүүлэн олгох, хэлбэр өөрчлөх, хугацааг сунгах, газар | ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/110 дугаар захирамж, Албаны даргын 2022 оны А/76 дугаар тушаал |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох асуудлуудыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх | | | |
| 35. | Газрын кадастрын мэдээллийн санд хяналт тавих ажлын хэсгийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын байршлын кадастрын зургийг шинээр бүртгэх, эргэлтийн цэг өөрчлөх, устгах, сэргээхтэй холбоотой асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх: | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улирал | Газрын тухай хууль болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалыг хэрэгжүүлэх |
| 36. | Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах | ДГЗБА | I-IV улирал | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт |
| 37. | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, түргэн үйлчилгээний цэгийн зөвшөөрөл өгсөн эрх бүхий байгууллагад албадан чөлөөлүүлэх санал хүргүүлэх, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улирал | Газрын тухай хуулийн 56.5 "Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна" дэх заалт; Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 34 дүгээр тогтоол |
| Зургаа. Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 38. | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах. | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улирал | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх |
| 39. | Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын нэгдсэн цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх. | ДГЗБА | I-IV улирал | Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоол |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 40. | Дүүрэг дэх газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил болон газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх |
| | Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийгдэх ажил | | | |
| 41. | Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах | ДГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |
| 42. | Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/39 дүгээр тогтоол шинэчлэгдсэн тохиолдолд газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах | ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |

## ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1 Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ

| Д/д | Дүүрэг | Хороо | Газрын байршил | Иргэдийн тоо | Газрын хэмжээ /га/ | Зориулалт | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Чингэлтэй | 7 | Хувьсгалчдын А-Г гудамж | 2 | 0.12 | Гэр бүлийн хэрэгцээ | I-IV улиралд | ЧДГЗБА |
| 2 | | 8 | Баруун, Зүүн тасганы гудамж | 1 | 0.01 | | | |
| 3 | | 9 | Дэнж, Усан сангийн гудамж | 5 | 0.18 | | | |
| 4 | | 10 | Дэнж, Чингэлтэйн гудамж | 3 | 0.10 | | | |
| 5 | | 11 | Нуурын гудамж | 1 | 0.02 | | | |
| 6 | | 12 | Булагийн гудамж | 5 | 0.25 | | | |
| 7 | | 13 | Сурагч, Сургуулийн гудамж | 1 | 0.02 | | | |
| 8 | | 14 | Хайлаастын гудамж | 1 | 0.04 | | | |
| 9 | | 15 | Жаргалантын гудамж | 1 | 0.04 | | | |
| 10 | | 16 | Согоотын гудамж | 8 | 0.43 | | | |
| 11 | | 17 | Зүрх уул, Баянхайрхан, Сурагчийн гудамж | 9 | 0.50 | | | |
| 12 | | 18 | Хандгайтын гудамж | 1 | 0.06 | | | |
| 13 | | 19 | Зээл, Тахилт, Доод, Дээд, Салхитын гудамж | 19 | 1.02 | | | |
| 14 | | 20 | Хувьсгалчдын-Г-ийн гудамж | 6 | 0.29 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | 21 | Булагийн гудамж | 6 | 0.35 | | | |
| 16 | | 22 | Согоот, Ар согоот | 7 | 0.38 | | | |
| 17 | | 23 | Чингэлтэй, Зүрх уул | 8 | 0.52 | | | |
| 18 | | 24 | Зуслан | 53 | 2.96 | | | |
| | | **Дүн** | | **137** | **7.28** | | | |

2.2. Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Зориулалт | Газрын хэмжээ /га/ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Шадивлан зуслан | Сургууль, цэцэрлэг | 0.4 | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 2. | Чингэлтэй дүүргийн 20 дугаар хороо | Хувьсгалчдын гудамж | Эрүүл мэндийн байгууллага | 0.1377 | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 3. | Чингэлтэй дүүргийн 22 дугаар хороо | Согоотын гудамж | Амины орон сууц | 5 | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 4. | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо | 30 а байрны баруун талд | Иргэд хүүхэд, залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв | 0.1173 | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 5. | Чингэлтэй дүүргийн | Шар хагтын ам | Ахмадын сувилал, амралтын төв | 8.7871 | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 6. | Нийт: | | 5 | **14.4248** | | |

2.3 Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Зориулалт | Газрын хэмжээ /га/ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо | Улсын их дэлгүүрийн зүүн талд, 1 дүгээр байрны ард талд | Нийтийн эдэлбэр | 0.2029 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 2. | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо | Болзоо цэцэрлэгт хүрээлэн орчим | Нийтийн эдэлбэр | 0.1520 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо | 37 дугаар байрны урд талд, 36 дугаар байрны зүүн талд | Нийтийн эдэлбэр | 0.1285 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 4. | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо | 5 дугаар байрны дунд талд | Нийтийн эдэлбэр | 0.0479 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 5. | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо | 51,52 дугаар байрнуудын дунд талд | Нийтийн эдэлбэр | 0.0541 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 6. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Шадивлан зуслан орчим | Нийтийн эдэлбэр | 0.0385 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 7. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Барилгын хөгжлийн төвийн баруун талд | Нийтийн эдэлбэр | 0.12 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| **Нийт** | | | | **0.7439** | | |

## ГУРАВ. НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ, ГАЗРЫН ЗӨРЧИЛ АРИЛГАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

### *3.1 Барилга байгууламжийн газрыг чөлөөлөх*

| д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Чөлөөлөх нэгж талбар, газрын хэмжээ /га/ | | Зориулалт | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | - | Сургууль | I-IV улиралд | НБГ, НГЗБА, НХОГ |
| 2. | Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | - | Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэг | I-IV улиралд | НБГ, НГЗБА, НХОГ |
| 3. | Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | - | Ногоон байгууламж | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 4. | Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо | Хайлааст, Хандгайт, Яргайт, Рашаан, Ногооны талбай гудамж | 2003 | 158.7 | Гэр хороолол дахин төлөвлөлт | I-IV улиралд | НГЗБА, НОСБГ, НОСК |
| 5. | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | - | Сургууль, спорт заал | I-IV улиралд | НБГ, НГЗБА, НХОГ |
| 6. | Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | - | Хүүхдийн цэцэрлэг | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 7. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Шадивлан зуслан | 6 | 0.4 | Сургууль, цэцэрлэг | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 8. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Жигжид | 1 | 0.1 | Олон нийтийн барилга байгууламж | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Жигжид | 8 | 0.551 | Олон нийтийн барилга байгууламж | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 8. | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 9. | Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 10. | Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 11. | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 12. | Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 13. | Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 14. | Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 15. | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 16. | Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 17. | Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 18. | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 19. | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20. | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 21. | Чингэлтэй дүүргийн 20 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 22. | Чингэлтэй дүүргийн 21 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 23. | Чингэлтэй дүүргийн 22 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 24. | Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 25. | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэр | 8 | 0.4 | Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| **Дүн** | | | **2162** | **160.471** | | | |

**3.2 Дэд төвүүдийн газрыг чөлөөлөх**

| **№** | **Дүүрэг, хороо** | **Газрын байршил** | **Чөлөөлөх нэгж талбар газрын хэмжээ /га/** | | **Зориулалт** | **Хугацаа** | **Хариуцах байгууллага** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй дүүргийн 10, 11, 12, 13 дугаар хороо | Дэнжийн 1000 дэд төв | 363 | 12.8 | Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж | I-IV улиралд | НГЗБА, НХОГ, АХБ |
| **Нийт** | | | **363** | **12.8** | | | |

**3.3 Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх**

| **№** | **Дүүрэг, хороо** | **Газрын байршил** | **Чөлөөлөх нэгж талбар, газрын хэмжээ /га/** | | **Зориулалт** | **Хугацаа** | **Хариуцах байгууллага** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо | Сервис центр орчим | - | - | Саарал усыг цуглуулах цөөрөм | I-IV улиралд | НГЗБА, НХОГ |

**3.4 Авто зам, замын байгууламжийн газрыг чөлөөлөх**

| **№** | **Дүүрэг, хороо** | **Газрын байршил** | **Чөлөөлөх нэгж талбар, газрын хэмжээ /га/** | **Зориулалт** | **Хугацаа** | **Хариуцах байгууллага** |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Чингэлтэй дүүргийн 7,8,9,10 дугаар хороо | Тасганы овооноос хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн дагуу Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замтай нийлэх чулуун болон хатуу хучилттай зам | 113 | 6.23 | Авто зам | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 2 | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо | 117 дугаар сургуулийн хойд талд | 4 | 0.18 | Авто зогсоол | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 3 | Төвийн 6 дүүрэгт | Дүүргийн нутаг дэвсгэрт | - | 37.0 | Авто зогсоол | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 4 | Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо | Доод салхит 12 дугаар гудамж 248 тоот | 1 | 0.06 | Сургуулийн зогсоол | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| **Нийт** | | | **118** | **43.47** | | | |

**3.5 Орц, гарц гаргах**

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Чөлөөлөх объектын тоо | газрын хэмжээ /га/ | Зөрчлийн хэлбэр | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо | Хувьсгалчдын В-13 гудамж 43а тоот | 1 | 0.069 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 2. | | Хувьсгалчдын Г гудамж 499 тоот | 1 | 0.0495 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 3. | | Хувьсгалчдын Г гудамж 597 тоот | 1 | 0.0417 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 4. | | Хувьсгалчдын Г гудамж 565 тоот | 1 | 0.0552 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 5. | | Хувьсгалчдын Г гудамж 540 тоот | 1 | 0.0347 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 6. | | Хувьсгалчдын Г гудамж 539 тоот | 1 | 0.0302 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | | Хувьсгалчдын Г гудамж 511 тоот | 1 | 0.0529 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| 8. | | Хувьсгалчдын Г гудамж 511 г тоот | 1 | 0.0474 | Орц, гарц | I-IV улиралд | ДЗДТГ, ДГЗБА |
| **ДҮН** | | | **8** | 0.3806 | | | |

*3.6 Зөрчил арилгах*

| **д/д** | **Дүүрэг, хороо** | **Газрын байршил** | **Чөлөөлөх объектын тоо** | **Объектын төрөл** | **Зөрчлийн хэлбэр** | **Хэрэгжүүлэх хугацаа** | **Хариуцах байгууллага** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чингэлтэй 1 дүгээр хороо | А4-р байрны зүүн талд | 2 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 2. | Чингэлтэй 1 дүгээр хороо | 1-р байрны зүүн талд | 4 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 3. | Чингэлтэй 2 дугаар хороо | Монхаус 33 дугаар байрны хойд талд | 10 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 4. | Чингэлтэй 2 дугаар хороо | Сансар КАтв-н урд | 15 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 5. | Чингэлтэй 4 дүгээр хороо | 12-р байрны хойд талд | 6 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 6. | Чингэлтэй 4 дүгээр хороо | 46-р байрны баруун хойд талд | 4 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 7. | Чингэлтэй 4 дүгээр хороо | 30а байрны баруун талд | 4 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 8. | Чингэлтэй 6 дугаар хороо | 61-р байрны хойд талд | 17 | Тоосгон гарааш | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Чингэлтэй 6 дугаар хороо | 41 дүгээр байрны зүүн хойд талд | 1 | Контейнер | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 10. | Чингэлтэй 16 дугаар хороо | Согоотын гудамж | 9 | Хашаа | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 11. | Чингэлтэй дүүргийн 1-5 дугаар хороо | Хороодын нутаг дэвсгэр | 90 | Автомат хаалт | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | I-IV улиралд | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| 12. | Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороо | Хороодын нутаг дэвсгэр | 62 | Хашаа, хайс | Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа | | ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА |
| **ДҮН** | | | **224** | | | | |

4. Газрын төлбөрийн орлого бүрдүүлэх чиглэлээр

| **№** | **Дүүрэг** | **Зориулалт** /нэгж талбар бүрийг зориулалтаар нь ангилна/ | **Газрын хэмжээ** | **$1м^2$ газарт ногдуулах төлбөрийн хэмжээ** | **Татвар тооцох хугацаа** | **Нийт төвлөрүүлэх төлбөрийн хэмжээ** /мян.төг/ | **Хариуцах байгууллага** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Дүүргийн хэмжээнд | Гэр бүлийн хамтын хэрэгцээ | 601205 | 24 | | 141,960,216.00 | НТГ, Дүүргийн татварын хэлтэс |
| 2. | | Төсөвт байгууллага | 986358 | 71 | | 412,215,829.00 | |
| 3. | | Нийтийн зориулалттай орон сууц | 147650 | 209 | | 52,594,582.00 | |
| 4. | | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ | 160409 | 483 | | 125,685,110.00 | |
| 5. | | Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц | 0 | 852 | | 0 | |
| 6. | | Бүх төрлийн авто зогсоол /газар дээрх, доорх/ | 1359 | 434 | | 833,856.00 | |
| 7. | | Нийтийн эдэлбэрийн газар | 1399 | 58 | | 218,244.00 | |
| 8. | | Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж | 0 | 110 | | 0 | |
| 9. | | Төмөр зам, нисэх онгоцны буудал | 0 | 101 | | 0 | |
| 10. | | Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар | 0 | 508 | | 0 | |
| 11. | | Шашин, сүм, хийд | 227721 | 573 | | 6,819,546.00 | |
| 12. | | Химийн хорт бодис арьс шир ноос ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр | 0 | 0 | | 0 | |
| 13. | | Бүх төрлийн үйлдвэрлэл /хөдөө аж ахуйгаас бусад/ | 15613 | 186 | | 6,255,036.00 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл | 0 | 13 | | 0 | |
| 15. | | Уурхайн эдэлбэр газар | 0 | 32 | | 0 | |
| **Нийт** | | | **2141714** | | | **746,582,419.00** | |